



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/436

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг Спутник-В буюу "Гам-КОВИД-Вак" вакцинаар дархлаажуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24, 35 дугаар зүйлийн 35.6, 35.7, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монгол Улсын Засгийн газрын санхүүжилтээр ханган нийлүүлэгдэх Оросын Холбооны Улсын Гамалейн судалгааны хүрээлэнгийн Спутник-В буюу "Гам-КОВИД-Вак" коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины эхний тунд хамрагдсан иргэдийг давтан тунгаар, тархвар судлалын заалтаар вакцинжуулах ажлыг 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Эхний ханган нийлүүлэлтээр хүлээн авсан "Гам-КОВИД-Вак" вакцинаар давтан тунд хамруулах шаардлагатай 65-аас дээш насны иргэдийг, хоёр дахь удаагийн ханган нийлүүлэлтээр хүлээн авах вакцинаар бусад зорилтот бүлгийн иргэдийг вакцинжуулах ажлыг зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Л.Энхсайхан), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Л.Баттөр), уг вакцины эхний тунд харьяалах орон нутгийн эрүүл мэндийн байгууллага дээр тархвар судлалын заалтаар үнэ төлбөргүй хамрагдсан иргэдийг вакцинжуулан, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын хэрэгжилтийг чанд мөрдөн ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус даалгасугай.

3. ОХУ-ын Гамалейн судалгааны хүрээлэнгийн Спутник-В буюу "Гам-КОВИД-Вак" вакцины хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

4. Дархлаажуулалтын цахим бүртгэлийн програмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Мэдээлэл технологийн хэлтэст, шаардлагатай компьютер бусад тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн

141211921

газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, вакцинжуулалтын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Д.Ганцэцэг)-т үүрэг болгосугай.

САЙД



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 1438 дугаар тушаалын хавсралт

ОХУ-ЫН ГАМАЛЕЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН СПУТНИК-В  
БУЮУ "ГАМ-КОВИД-ВАК" ВАКЦИН, ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

д/д	Аймаг, дүүрэг	II тунд хамрагдах иргэдийн тоо	Шаардагдах тоо хэмжээ		
			Вакцин (хүн тун)	Тариур 3 мл	Аюулгүй хайрцаг
1	Багануур	600	600	600	6
2	Багахангай	100	100	100	1
3	Баянгол	3,500	3,500	3,500	35
4	Баянзүрх	3,000	3,000	3,000	30
5	Налайх	700	700	700	7
6	Сонгинохайрхан	3,000	3,000	3,000	30
7	Сүхбаатар	3,000	3,000	3,000	30
8	Хан-Уул	2,000	2,000	2,000	20
9	Чингэлтэй	2,600	2,600	2,600	26
10	Орхон аймаг	500	500	500	5
11	Дархан-Уул аймаг	1,000	1,000	1,000	10
<b>ДҮН</b>		<b>20,000</b>	<b>20,000</b>	<b>20,000</b>	<b>200</b>